

“Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн
Удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 10 дүгээр сарын 28-
ны өдрийн 51 тоот тогтоолын хавсралт



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО”
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмыг “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дүрмийн 28.1.3 дахь заалтад үндэслэн боловсруулж батлав.
- 1.2. Энэ журмын зорилго нь “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” Нийтийн эрх зүйн хуулийн этгээд (цаашид “НЭЗХЭ” гэх)-ийн Удирдах Зөвлөл, Хяналтын зөвлөлд нэр дэвшихтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.3. Сонгуулийн үйл ажиллагаа нь НЭЗХЭ-ийн дүрэм заасны дагуу улс орны нийтлэг эрх ашиг, хүний эрхийг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах, гишүүдийн эрх, тэгш оролцоог эрхэмлэнэ.

ХОЁР. НЭР ДЭВШҮҮЛЭХ ТУХАЙ

- 2.1. Албан тушаалд нэр дэвшигч нь энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу нэр дэвших хүсэлтээ Нэгдсэн хуралдаан эхлэхээс тав хоногийн өмнө Ажлын албанд хүргүүлнэ. Гүйцэтгэх захирал мэдүүлэг хүлээн авах сүүлийн өдрөөс хойш хоёр хоногийн дотор нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтыг товч намтрын хамт Салбар холбоодод танилцуулахаар хүргүүлсэн байна.
- 2.2. Нэр дэвшигчид өөрийн Салбар холбооны шийдвэр бүхий албан бичгийг мэдүүлэгтээ хавсаргана.
- 2.3. Албан тушаал тус бүр дээр НЭЗХЭ-ийн дүрэмд зааснаас тооноос бага, нөхөн сонгох тохиолдолд нөхөн сонгох орон тооноос бага нэр дэвшигчийн мэдүүлэг ирсэн бол нэр дэвшигчийн мэдүүлгийг хүлээн авах хугацааг Нэгдсэн хуралдаан эхлэхээс хоёр хоногийн өмнө хүртэл сунгана.
- 2.4. Хяналтын зөвлөлд нэр дэвшигч нь аялал жуулчлалын салбарт гурав ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байна.
- 2.5. Удирдах зөвлөлийн гишүүн, Хяналтын зөвлөлийн гишүүний үүрэг гүйцэтгэх хугацаа нь хоёр жилийн хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлэх ба нөхөн сонгуулиар сонгогдсон болон томилогдсон албан тушаалтнууд бүрэн эрхийн хугацааны үлдсэн хугацаанд эрхээ хэрэгжүүлнэ.
- 2.6. Онцгой нөхцөлийн улмаас Нэгдсэн хуралдаан хойшлогдсон тохиолдолд дараагийн сонгууль хүртэлх хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлж буй албан тушаалтнууд бүрэн эрхээ тодорхой бус хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.7. Нэр дэвшигч нь НЭЗХЭ-ийн дүрмийн шаардлагыг хангасан этгээд байх энэхүү журамд заасан нэр дэвшигчийн анкетыг зохих ёсоор бөглөсөн байна.

2.8. Саналын эрхтэй Нэгдсэн хуралдааны төлөөлөгчөөс Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд нэр дэвшигчдийг сонгуульд оролцуулахаас татгалзуулах саналтай нэр дэвшигч байна гэж үзвэл энэ тухай санал, үндэслэлээ сонгууль болохоо 3-с доошгүй хоногийн өмнө Хяналтын зөвлөл, Ажлын албанд бичгээр ирүүлнэ.

2.9. Нэр дэвшигчдийн материалыг шаардлага хангаж буй эсэхийг Хяналтын зөвлөл, Ажлын алба үнэлэлт дүгнэлт өгч, аливаа зөрчилгүй гэж үзвэл нэр дэвшигчийг бүртгэж, сонгуульд оролцох нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.

ГУРАВ. ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь НЭЗХЭ-ийн дүрмийн 22 дугаар зүйлд заасны дагуу дараах шаардлагуудыг хангасан байна.

3.1.1. Аялал жуулчлалын салбарт 5 буюу түүнээс дээш жил ажилласан байх;

3.1.2. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор эдэлж байгаа ял, шийтгэлгүй байх;

3.1.3. Нэгдсэн хуралдаанаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчиж, ёс зүйн болон мэргэжлийн алдаа, дутагдал гаргаж байгаагүй байх;

3.1.4. Хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээд нь НЭЗХЭ-ийн удирдах албан тушаал эсхүл Хяналтын зөвлөлд ажилладаггүй байх;

3.1.5. Удирдах зөвлөлд нэр дэвшигчийн материалд харьяалагдах Салбар холбооны нэр дэвшигчийг дэмжиж буй тухай албан бичгийг хавсаргасан байна.

3.2. Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дүрэмд өөрөөр заагаагүй бол ямарваа нэг шаардлага тавигдахгүй.

ДӨРӨВ. СОНГУУЛЬ ЯВУУЛАХ, САНАЛ АВАХ АЖИЛЛАГАА

4.1. Сонгуулийн үйл явц дараах дэгийн дагуу явагдана.

4.2. Ажлын алба нь Нэгдсэн хуралдааны төлөөлөгчдийг танилцуулан, хуралд оролцогсдыг бүртгэснээр тэдгээр төлөөлөгчдийн сонгуульд оролцох, саналаа өгөх бүрэн эрх нээгдэнэ.

4.3. Ажлын алба энэхүү журмын дагуу нэр дэвших материалаа зохих ёсоор, бүрэн ирүүлсэн, шаардлага хангасан нэр дэвшигчдийн танилцуулгыг ээлжит болон ээлжит бус хуралд танилцуулан сонгуулийн санал хураалтыг эхлүүлнэ.

4.4. НЭЗХЭ-ийн Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох сонгуульд дүрмийн 21.2-д заасан чиглэлийн нэр дэвшигчдээс хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчдийг, үлдсэн нэр дэвшигчдээс дүрмийн 21.1-д заасан тоо хүртэл хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцно.

4.5. Дүрмийн 19.2 дугаарт заасан нэр дэвшигчдээс үлдсэн нэр дэвшигчдээс нэг салбарын төлөөлөл хамгийн дүрмийн 21.1-д заасан тоо хүртэл хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцно. Ингэхдээ нэг үйл ажиллагааны чиглэлийн төлөөлөл хамгийн ихдээ 7 хүртэл гишүүн сонгогдоно.

4.6. НЭЗХЭ-ийн дүрмийн 19.5-т заасан үндэслэлийн дагуу энэ дүрэмд зааснаас бусад асуудлаарх санал хураалтыг нууцаар явуулна.

ТАВ: ТООЛЛОГЫН КОМИСС, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Тооллогын комиссыг НЭЗХЭ-ийн дүрмийн 20 дугаар зүйлд заасныг үндэслэж зохион байгуулна.

5.2. Тооллогын комиссыг 7 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэйгээр Нэгдсэн хуралдаанд оролцож буй нийт гишүүдийн дундаас хурал удирдах бүрэлдэхүүн нээлттэйгээр сонгож, тооллогын комиссын гишүүд дотроосоо даргаа сонгоно.

5.3. Тооллогын комисс НЭЗХЭ-ийн 20.2 дахь хэсэгт заасныг үндэслэж дараах эрх, үүрэгтэй:

5.3.1. Нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцогчдын ирцийг тогтоож, хуралдаан даргалагчид мэдээлэх;

5.3.2. Төлөөлөгчдийн саналын эрхийг баталгаажуулах;

5.3.3. Нэгдсэн хуралдаанд оролцож санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдох асуудалд тайлбар өгөх;

5.3.4. Санал өгөх зааврыг тайлбарлах;

5.3.5. Санал өгөх зааврын хэрэгжилт болон хуралд оролцогчдын санал өгөх эрхийг хангах;

5.3.6. Санал хураалтыг санал авах хуудсаар явуулж байгаа тохиолдолд саналын хуудсыг тоолж, хүлээж авах;

5.3.7. Санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх;

5.3.8. Саналыг тоолж, дүнг нэгтгэн, санал хураалтын тооллогын комиссын даргын гарын үсгээр баталгаажуулан Нэгдсэн хуралдаанд танилцуулах;

5.3.9. Саналын хуудсыг дахин тоолох санал гарсан тохиолдолд Нэгдсэн хуралдааныг зохион байгуулах комиссын хяналт дор дахин тоолох;

5.3.10. Нууцаар санал хураах тохиолдолд гишүүдийн санал өгөх нөхцөл, боломжийг бүрэн хангах, саналын хуудсыг дахин тоолох санал гараагүй нөхцөлд Нэгдсэн хуралдааны шийдвэрээр устгах;

5.4. Тооллогын комисс нь тооллогын явцтай холбоотой маргаан гарсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл тооллогын комиссын гишүүдийн энгийн олонхын саналаар тус комиссыг шинээр сонгож хяналтын тооллого хийнэ.

ЗУРГАА. СОНГУУЛИЙН ДҮНГ ГАРГАХ

6.1. Ээлжит болон ээлжит бус хуралдаанаар НЭЗХЭ-ийн Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд нэр дэвшигчдийн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн дүнг дараах аргачлалаар явуулна.

6.2. Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд нэр дэвшигч нь НЭЗХЭ-ийн дүрэмд заасны дагуу хурлын төлөөлөгчдийн энгийн олонх (50+)-н санал авсан тохиолдолд сонгогдоно.